



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Гуравдугаар дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2022/167/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Архангай аймаг 2022 он</p>	<p>Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас:7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК Утас: 99099119 Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	4
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Материаллаг байдал .....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал .....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт .....	17
4.1 Залруулсан алдаа .....	18
4.2 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	19

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль



## АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг  
Утас/Факс: 976-70333141  
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

Г ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ГУРАВДУГААР  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Б.ЭНХБОЛД  
ТАНАА

2022.07.22 № 38  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Аудитын санал дүгнэлт Г

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Гуравдугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэбулган сумын Гуравдугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг..

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>205,121,123.98</u></b>	<b><u>235,281,914.16</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	205,121,123.98	235,281,914.16
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,284,900.00	4,988,210.00
35130	Эм боох материал	1,284,900.00	4,988,210.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	203,836,223.98	230,293,704.16
35420	Аж ахуйн материал	168,464,368.48	185,921,418.66
35450	Барилгын засварын материал	12,712,023.00	21,712,453.00
35470	Бусад хангамжийн материал	22,659,832.50	22,659,832.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>575,470,945.33</u></b>	<b><u>1,303,628,652.31</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	575,470,945.33	1,303,628,652.31
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	371,184,695.33	1,099,764,902.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,932,225,219.89	2,557,032,444.51
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,761,854,407.69	-
			1,771,429,616.95
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,910,000.00	1,910,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-1,910,000.00	-1,910,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	241,271,353.45	169,002,541.61
39206	Хуримтлагдсан элэгдэл	-201,345,729.51	-27,674,563.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	173,106,711.88	142,959,672.04
39208	Хуримтлагдсан элэгдэл	-97,211,956.22	-49,592,093.76
39214	Бусад үндсэн хөрөнгө	41,967,500.00	41,356,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-10,467,500.04	-13,356,300.08
39217	Ном	53,493,503.57	51,466,517.95
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	204,286,250.00	203,863,750.03
39301	Програм хангамж	3,125,298.00	3,400,298.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,469,048.00	-3,166,547.97
39303	Бусад биет бус хөрөнгө	203,630,000.00	203,630,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	00.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>780,592,069.31</u></b>	<b><u>1,538,910,566.47</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>4,501,373.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	4,501,373.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	4,501,373.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	4,501,373.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>780,592,069.31</u></b>	<b><u>1,534,409,193.47</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	780,592,069.31	1,534,409,193.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,040,869,958.41	1,040,869,958.41
51101	Өмч: - төрийн	1,040,869,958.41	1,040,869,958.41
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-1,673,743,943.93	-918,433,777.84
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,673,743,943.93	-
			1,672,250,902.00
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	753,817,124.16
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	00.00	00.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,413,466,054.83	1,411,973,012.90
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>780,592,069.31</u></b>	<b><u>1,538,910,566.47</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,230,329,360.89</b>	<b>2,604,800,535.72</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>104,214,050.89</b>	<b>783,700,933.90</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	104,214,050.89	783,700,933.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	104,214,050.89	783,700,933.90
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	104,214,050.89	783,700,933.90
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>169,197,400.00</b>	<b>301,325,301.82</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>956,917,910.00</b>	<b>1,519,774,300.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	956,917,910.00	1,519,774,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	34,339,601.82
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	26,421,901.82
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	7,917,700.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	169,197,400.00	266,985,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	169,197,400.00	266,985,700.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,606,099,886.81</b>	<b>1,843,201,481.71</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,606,099,886.81</b>	<b>1,843,201,481.71</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,600,757,976.81	1,776,003,181.71
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	758,201,605.00	1,253,092,782.35
210101	Үндсэн цалин	538,767,914.00	787,016,476.64
210102	Нэмэгдэл	157,585,931.00	363,390,044.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00
210104	Урамшуулал	61,847,760.00	102,686,261.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	91,817,720.00	164,504,317.65
210201	Тэтгэврийн даатгал	66,210,901.00	115,745,138.58
210202	Тэтгэмжийн даатгал	5,906,496.00	12,353,011.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,763,824.00	9,859,149.16
210204	Ажилгүйдлийн даатгал	1,355,827.00	2,413,174.47
210205	Эрүүл мэндийн даатгал	14,580,672.00	24,133,843.92
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	120,797,660.00	262,673,873.00
210301	Гэрэл, цахилгаан	1,980,473.00	5,905,299.00
210302	Түлш, халаалт	114,723,260.00	242,789,876.00
210303	Цэвэр, бохир ус	4,093,927.00	13,978,698.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,235,392.00	24,065,244.60
210401	Бичиг хэрэг	101,110.00	3,381,500.00
210402	Тээвэр, шатахуун	207,800.00	1,794,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	193,882.00	734,090.00
210404	Ном, хэвлэл	266,450.00	209,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	968,840.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	226,150.00	10,588,324.60
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	6,389,490.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	291,300.00	4,281,390.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	291,300.00	4,178,390.00

Архангай аймгийн Ерөнхий боловсролын Гуравдугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	00.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	103,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	204,960.00	11,415,770.00
210604	Урсгал засвар	204,960.00	11,415,770.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	100,000.00	403,800.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	100,000.00	403,800.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	833,000.00	2,037,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	433,000.00	2,037,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	627,276,339.81	53,528,804.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,007,790.00	13,321,727.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	623,268,549.81	40,207,077.11
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	5,341,910.00	67,198,300.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,341,910.00	59,950,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	1,690,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,341,910.00	56,900,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,360,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	00.00	7,247,700.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>-375,770,525.92</u></b>	<b><u>761,599,054.01</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	7,781,929.85
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	7,781,929.85
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	00.00	-7,781,929.85
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>-375,770,525.92</u></b>	<b><u>753,817,124.16</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	00.00	00.00	00.00	00.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,040,869,958.41</b>	<b>1,413,466,054.83</b>	<b>-1,673,743,943.93</b>	780,592,069.31
<b>2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>1,040,869,958.41</b>	<b>1,413,466,054.83</b>	<b>-1,673,743,943.93</b>	780,592,069.31
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,493,041.93	1,493,041.93
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,040,869,958.41</b>	<b>1,413,466,054.83</b>	<b>-1,672,250,902.00</b>	782,085,111.24
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-1,493,041.93	00.00	-1,493,041.93
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	753,817,124.16	753,817,124.16
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,040,869,958.41</b>	<b>1,411,973,012.90</b>	<b>-918,433,777.84</b>	1,534,409,193.47

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,126,115,310.00</u></b>	<b><u>1,821,099,601.82</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,126,115,310.00</b>	<b>1,821,099,601.82</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>956,917,910.00</b>	<b>1,519,774,300.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	956,917,910.00	1,519,774,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>00.00</b>	<b>34,339,601.82</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	26,421,901.82
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	7,917,700.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>169,197,400.00</b>	<b>266,985,700.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	169,197,400.00	266,985,700.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>984,923,403.00</u></b>	<b><u>1,809,558,059.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>984,923,403.00</b>	<b>1,809,558,059.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>978,769,693.00</b>	<b>1,742,359,759.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>758,201,605.00</b>	<b>1,251,027,800.00</b>
210101	Үндсэн цалин	538,767,914.00	791,560,449.98
210102	Нэмэгдэл	157,585,931.00	350,218,077.02
210104	Урамшуулал	61,847,760.00	109,249,273.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>91,632,246.00</b>	<b>166,569,300.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	66,025,427.00	122,272,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,906,496.00	11,074,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,763,824.00	8,859,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,355,827.00	2,214,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,580,672.00	22,148,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>120,797,660.00</b>	<b>262,329,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,980,473.00	5,905,299.00
210302	Түлш, халаалт	114,723,260.00	238,288,503.00
210303	Цэвэр, бохир ус	4,093,927.00	18,135,198.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,705,032.00</b>	<b>13,459,159.00</b>
210401	Бичиг хэрэг	880,800.00	4,639,103.00
210402	Тээвэр, шатахуун	207,800.00	1,750,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	193,882.00	1,366,837.00
210404	Ном, хэвлэл	439,850.00	277,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	420,590.00	1,187,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,562,110.00	4,238,519.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,358,800.00</b>	<b>13,663,700.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	308,800.00	10,951,700.00
210502	Хоол, хүнс	00.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,050,000.00	2,712,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>00.00</b>	<b>23,121,700.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	3,696,000.00
210604	Урсгал засвар	00.00	19,425,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>100,000.00</b>	<b>403,800.00</b>
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	100,000.00	403,800.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>833,000.00</b>	<b>2,139,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	433,000.00	2,139,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,141,350.00</b>	<b>9,645,800.00</b>

Архангай аймгийн Ерөнхий боловсролын Гуравдугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,141,350.00	9,645,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,153,710.00</b>	<b>67,198,300.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	6,153,710.00	59,950,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,153,710.00	56,900,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	3,050,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	00.00	7,247,700.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>141,191,907.00</u></b>	<b><u>11,541,542.82</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>6,170,000.00</b>	<b>11,541,542.82</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,170,000.00</b>	<b>11,541,542.82</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	6,170,000.00	11,541,542.82
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,170,000.00	11,541,542.82
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-6,170,000.00</u></b>	<b><u>-11,541,542.82</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	135,021,907.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	135,021,907.00	00.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,786,760,000.00	1,786,760,000.00	0.00	100.0
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,786,760,000.00	1,786,760,000.00	0.00	100.0
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,726,809,400.00	1,726,809,400.00	0.00	100.0
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,251,027,800.00	1,251,027,800.00	0.00	100.0
210101	Үндсэн цалин	878,839,100.00	791,560,449.98	87,278,650.02	90.1
210102	Нэмэгдэл	266,478,200.00	350,218,077.02	83,739,877.02	131.4
210104	Урамшуулал	105,710,500.00	109,249,273.00	-3,538,773.00	103.4
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	166,569,300.00	166,569,300.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	122,272,600.00	122,272,600.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	11,074,200.00	11,074,200.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,859,300.00	8,859,300.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,214,900.00	2,214,900.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	22,148,300.00	22,148,300.00	0.00	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	262,329,000.00	262,329,000.00	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	8,462,100.00	5,905,299.00	2,556,801.00	69.8
210302	Түлш, халаалт	234,636,300.00	238,288,503.00	-3,652,203.00	101.5
210303	Цэвэр, бохир ус	19,230,600.00	18,135,198.00	1,095,402.00	94.3
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,007,900.00	12,007,900.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	3,561,900.00	3,642,201.18	-80,301.18	102.2
210402	Тээвэр, шатахуун	1,750,000.00	1,750,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,357,500.00	1,366,837.00	-9,337.00	100.7
210404	Ном, хэвлэл	829,400.00	317,642.82	511,757.18	38.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	850,700.00	692,700.00	158,000.00	81.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,658,400.00	4,238,519.00	-580,119.00	115.8
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	13,663,700.00	13,663,700.00	0.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,951,700.00	10,951,700.00	0.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,712,000.00	2,712,000.00	0.00	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,156,700.00	7,156,700.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.00	2,500,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	4,656,700.00	4,656,700.00	0.00	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	403,800.00	403,800.00	0.00	100.0

Архангай аймгийн Ерөнхий боловсролын Гуравдугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	403,800.00	403,800.00	0.00	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,414,500.00	2,414,500.00	0.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,414,500.00	2,414,500.00	0.00	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	11236700.00	11236700.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00	0.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,236,700.00	11,236,700.00	0.00	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	59950600.00	59950600.00	0.00	100.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	59,950,600.00	59,950,600.00	0.00	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	56,900,600.00	56,900,600.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,050,000.00	3,050,000.00	0.00	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,786,760,000.00	1,786,760,000.00	0.00	100.0
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,519,774,300.00	1,519,774,300.00	0.00	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,519,774,300.00	1,519,774,300.00	0.00	100.0
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	00.00	00.00	0.00	
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	266,985,700.00	266,985,700.00	0.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	266,985,700.00	266,985,700.00	0.00	100.0
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00	0.00	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00	0.00	
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	00.00	00.00	0.00	
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	00.00	00.00	0.00	
610001	Төсвийн байгууллага	00.00	00.00	0.00	
610002	Төсвөөс гадуур байгууллага	00.00	00.00	0.00	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	96	97	-1	101.0
620001	Удирдах ажилтан	01	01	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	72	73	-1	101.4
620003	Үйлчлэх ажилтан	23	23	0	100.0
620004	Гэрээт ажилтан	00	00	0	
<b>63</b>	<b>Суралцагчдын тоо (жилийн дунджаар)</b>	1,513	1,513	0	100.0
<b>630</b>	<b>Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид</b>	1,513	1,513	0	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>27,091,901.82</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>27,091,901.82</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		27,091,901.82
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		1,491,901.82
210401	Бичиг хэрэг		996,901.82
210402	Тээвэр, шатахуун		00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		00.00
210404	Ном, хэвлэл		00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		495,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>		00.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		00.00
210502	Хоол, хүнс		00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		22,465,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		7,696,000.00
210602	Тавилга		00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		00.00
210604	Урсгал засвар		14,769,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	0.00	3135000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		3,135,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	27091901.82
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		27,091,901.82
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		00.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		26,421,901.82
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		670,000.00
131106	Төсвийн урамшуулал		00.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын гуравдугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн

аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, шилэн дансны хууль, 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ийн аудитор Л.Амарзаяа, аудиторын туслах Ц.Аюушжав нар гүйцэтгэж, чанарын хяналтыг менежер Ж.Ням-Осор, Захирал Д.Баатарсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэбулган сумын Гуравдугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 05 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Гуравдугаар сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Бүх шатны сургалтын байгууллагын багш бүр хичээл, сургалтын бэлтгэлийг чанартай ханган, үр дүнтэй хэрэгжүүлж, багш, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоо хамтын ажиллагааг өргөжүүлж, суралцагчийн хөгжил, төлөвшилд ахиц гаргах”-д оршино гэж тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургууль хүний хөгжлийн төв байх
- Ажлын хариуцлага ёс зүйг дээшлүүлж хууль дүрмийг хэрэгжүүлэх
- Сургалтын чанар үр дүнг дээшлүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороосон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор батлагдсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналт шалгалтын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хичээл сургалт, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, хөдөлмөрийн сахилга бат, хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүү аж ахуйн үйл ажиллагааны өнөөгийн байдалд хяналт шалгалт хийж ажилласан байна. Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад

хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Гуравдугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д зааснаар тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар/, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн/, хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт/, нэмэлт төсвийн гүйцэтгэлийн дагуу иж бүрэн бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр “Батлагдсан төсөв”-ийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 17.9 сая төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 13.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Гуравдугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 758.3 сая төгрөгөөр буюу 197.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн дансанд гарсан өөрчлөлт байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	205.1	235.3	30.2
Үндсэн хөрөнгө	575.5	1,303.6	728.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>780.6</b>	<b>1,538.9</b>	<b>758.3</b>
Өр төлбөр	0	4.5	4.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	780.6	1,534.4	753.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>780.6</b>	<b>1,538.9</b>	<b>758.3</b>

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын данс нь 205.1 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 117.4 сая, БСШУЯамнаас үнэ төлбөргүй хүлээн авсан 19.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, тайлант онд 99.9 сая төгрөгөөр хасагдаж, 6.4 сая төгрөгийн материал акталж эцсийн үлдэгдэл 235.3 сая төгрөг болж 30.2 мянган төгрөгөөр өссөн байна
- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 728.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 11.5 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 631.5 сая, үндсэн хөрөнгө дахин үнэлж нэмсэнтэй холбоотой 133.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, үндсэн хөрөнгийн дахин үнэлэхтэй холбоотойгоор данснаас 256.1 сая төгрөгийн хөрөнгө хассан байна. Хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 2,075.3 сая төгрөг байснаас тайлант хугацааны элэгдэл 40.2 сая төгрөгөөр нэмэгдсэн, үндсэн хөрөнгийн дахин үнэлэхтэй холбоотойгоор данснаас хассан элэгдэл 248.3 сая төгрөгөөр тус тус хасагдаж үндсэн хөрөнгө 1,867.1 төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- Өр төлбөр данс нь 4.5 сая төгрөгөөр өссөн ба энэ нь сургуулийн урлаг заал ашиглалтад орсонтой холбоотойгоор 2021 онд төсөвт түлш халаалтын зардлыг тусгаж өгөөгүйгээс шалтгаалжээ.
- Цэвэр хөрөнгө өмчийн дүн 753.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 783.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр шилжүүлсэн авсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	956.9	1,519.8	562.9
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	169.2	267.0	97.8
Үндсэн үйл ажиллагааны орлого		7.9	7.9
Нэмэлт санхүүжилтийн орлого		26.4	26.4
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	104.2	764.6	660.4
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	19.1	19.1
<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>1,230.3</b>	<b>2,604.8</b>	<b>1,374.5</b>
Цалин, шимтгэлийн зардал	850.0	1,417.6	567.6
Бараа үйлчилгээний зардал	122.6	302.8	180.2
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.8	2.0	1.2
Бараа үйлчилгээний бусад зардал	627.3	53.5	(573.8)
Урсгал шилжүүлэг	5.3	67.2	61.9
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		7.8	7.8
<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>1,606.0</b>	<b>1,850.9</b>	<b>244.9</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(375.7)</b>	<b>753.9</b>	<b>1,129.6</b>

Тус сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 97.8 сая төгрөг буюу 57.8 хувиар өссөн нь санхүүжилт өссөнтэй холбоотой байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 1,786.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 1,786.8 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 1,786.8 сая төгрөгийн төсөв баталснаас гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,786.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,786.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,786.8 сая төгрөг буюу 100.0 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 27.1 сая төгрөгийн санхүүжилт авч 19.8 сая төгрөгийн зарцуулалт хийж 7.2 сая төгрөг төсөвт төвлөрүүлсэн байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 624.8 сая төгрөгийн сургуулийн урлаг заал шинээр ашиглалтад оруулж ажилласан нь түлш халаалтын зардлын өр төлбөрийн үлдэгдэл 4.5 сая төгрөгөөр өсөхөд нөлөөлсөн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

Тус байгууллага нь 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 2 үндсэн зорилтын хүрээнд 41 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 97 хувь байна.

Тайлант онд хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 4 арга хэмжээнд зориулан нийт 1,786.8 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 1,786.8 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд төсвийн гүйцэтгэл 100 хувь байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:

1. Тус сургууль бага ангийн багш 1 ажилтны орон тоон дээр нөхөн томилгоо хийсэн байна.
2. Албан томилолт, бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус сургууль нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 143 мэдээллийг 100% хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Дараах зөрчлүүд илрэв. Үүнд:

Тайлангийн жилд тус сургуулийн бага ангийн багш Ч.Тогооч эрүүл мэндийн шалтгааны улмаас 2021 оны 3 дугаар сарын 01-ны өдөр захирлын Б/28 тоот тушаалаар ажлаас түр чөлөөлөгдсөн ба 2021 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн Б/62 тоот тушаалаар хөдөлмөрийн багшийн орон тоон дээр багасгасан цагаар ажиллуулахаар томилон нийт 5.9 сая төгрөгийн цалингийн зардал гаргасан байна.

**Шийдвэрлэсэн нь:** Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.2-д Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх гэснийг хэрэгжүүлээгүй 5.9 сая төгрөгийн зардал гаргасан тул албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт нь холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 8.9 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн ба 100 хувь хэрэгжүүлсэн байна.

#### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарч үзэх асуудалгүй болно.

### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,857.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,852.9 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 4.2 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 4.2 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 17.9 сая төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

#### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Цалингийн өглөг дансны бүртгэлийг 4.2 сая төгрөгөөр зөрүүтэй, алдаатай бүртгэсэн.
- Үлдэх өртөггүй 1,852.9 сая хөрөнгийг ашиглалтын хугацааг сунгаж орлого авахдаа анхны өртгөөр авсныг тус тус залруулав

#### **4.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. *Балансын данстай холбоотой асуудал***

1.1. Илрүүлэлт: Харилцагчийн тооцоог нэг тооцооны дансаар дамжуулж бүртгээгүйгээс харилцагчийн тооцоонд бүртгэлээр тавих хяналт алдагдсан байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13,14-р заалтууд, УСНББУС-г мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

##### **2. *Зардлын данстай холбоотой асуудал***

2.1. Илрүүлэлт: Хог тээвэрлэлттэй холбоотой 0.04 сая төгрөгийн шатахуун авахаар төлбөрийн хүсэлт дээр шатахууны зардлаас гаргах хүсэлт гаргасан боловч Төрийн сангийн гүйлгээ хийхдээ шуудан холбооны зардлаас гаргасан байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13,14-р заалтууд, Төрийн сангийн төлбөр тооцоо хийх журмыг мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

-----oOo-----

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Ерөнхий боловсролын Гуравдугаар сургууль	4	1,857.10	2	1,852.90	0	0	0	0	2	4.2
Дүн		4	1,857.10	2	1,852.90	0	0	0	0	2	4.2
Санхүүгийн тайлангийн аудитын шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Ерөнхий боловсролын Гуравдугаар сургууль	1	5.90	0	0	0	0	1	5.90	0	0
Дүн		1	5.90	0	0	0	0	1	5.90	0	0
Нийт дүн		5	1,863.00	2	1,852.90	0.00	0.00	1	5.90	2.00	4.20